

**/БАРИМТ БИЧГИЙН ЖИНХЭНЭ ЭЗЭМШИГЧ МӨН ЭСЭХИЙГ ТОГТООХ ТУХАЙ/**

**Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн**

**анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь**

\_\_\_он\_\_\_сарын\_\_\_ны өдөр  
Сайншанд сум

**Нэхэмжлэгч:** Боржгон овогт Батын Ургамал Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр баг Аюушийн 1-1 тоотод оршин суух, утас:96352624

**Нэхэмжлэлийн шаардлага:** Батын Ургамалын баримт бичгийн жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоолгох тухай

**Нэхэмжлэлийн үндэслэл :** Миний би Б.Ургамал нь 1967 оны 01 сарын 05-ны өдөр Дорноговь аймгийн Иххэт суманд төрсөн юм. Тухайн үед төрсөний гэрчилгээг эмээ маань авсан бөгөөд өөрөөрөө овоглож буюу Цэндийн Ургамал гэж авсан. Миний аав Бат сургуульд ороход Батын Ургамал гэж бүртгүүлсэн бөгөөд түүнээс хойш миний ихэнх баримт бичиг болох иргэний үнэмлэх, хөдөлмөрийн дэвтэр, эрүүл мэндийн дэвтэрүүд Батын Ургамал гэж бичигдсэн байна. Гэвч 1997 онд авсан хөдөлмөрийн дэвтэр дээр Цэндийн Ургамал гэж бичигдсэн бөгөөд тэтгэвэрт гарах гэтэл баримт бичигт овог зөрүүтэй бичигдсэнээс болоод миний ажилласан жил хасагдаж тооцогдох болоод байгаа учир миний баримт бичгийн жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг нотлох баримтуудыг үндэслэн тогтоож өгнө үү?

Нэхэмжлэл гаргасан: /гарын үсэг/ Б.Ургамал

Нэхэмжлэлд :

- 1.Төрсний гэрчилгээ /нотират/
2. Нотлох баримтууд (Баярын бичиг, зураг г.м)
- 3.Иргэний үнэмлэхний хуулбар /ног/
- 4.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт1  
70200 төгрөг
5. Хөдөлмөрийн дэвтрийн хуулбар /ног/
- 6.Нэхэмжлэл 1% зэргийг хавсаргав
7. Гэрчээр асуулгах хүсэлт

Улсын тэмдэгтийн хураамж төлөхдөө шүүхэд хандах болон Дорноговь аймгийн Татварын газарт хандан төлбөрийн даалгавар үүсгүүлж хураамжаа банкинд тушаана.  
Анхаарах: /Та цаасны зүүн захаас 30 мм, дээд, доод захаас 20мм, баруун захаас 15 мм зайтай бичнэ/

**/Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгнө/ Шүүхийн утас: 70522144, 92172020**